



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/125

Чингис хот

Цалин нэмэх тухай

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар батлагдсан “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журам”-ын 111.4 дэх заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/120 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.4.2-ын “в” заалт, 136.5.2-ын “г” заалт, цагдаагийн газрын даргын зөвлөлийн 2017 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит 14 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тулгар төрийн 2226 жил, Их Монгол улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Хан Хэнтий уулын аймаг байгуулагдсаны 94 жилийн ойн баяр наадмын хэвийн үйл ажиллагааг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, наадамчин олны аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах зорилгоор “Цагдаагийн газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Б/74 дүгээр тушаалаар бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэглэлд шилжүүлэн ажиллуулах тухай” тушаалын хэрэгжилтийг ханган, идэвхи, зүтгэл гарган үр бүтээлтэй, санаачлагатай ажилласан 6 алба хаагчийн албан тушаалын үндсэн цалинг тус бүр 20.0 хувиар нэмсүгэй.

2. Албан тушаалын үндсэн цалинг нэмэх алба хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Хавсралтад заагдсан 6 алба хаагчийн албан тушаалын үндсэн цалинг заасан хувиар нэмж бодож олгохыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирлагын тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Чинбаатарт даалгасугай.

5. Тушаалын хуулбарыг хувийн хэрэгт нь хавсаргахыг Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад П.Алтантуяад үүрэг болгосугай.

6. Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА



Ж.БОЛД

Газрын даргын 2017 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 9/125 тоот
тушаалын хавсралт

ЦАЛИН НЭМЭХ АЛБА ХААГЧДЫН НЭРС

1. а/д Д.Амаржаргал
2. а/д Д.Оюунтуяа
3. д/ч Б.Оюунцэцэг
4. а/х Ц.Хүдэрээ
5. д/ч Ц.Болдоо
6. а/а Д.Алтансүвд